

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг  
Биеийн тамир, спортын газрын даргын 2018 оны 09 дугаар  
сарын 14-ний өдрийн 1/ дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**САЛБАРЫН “ШИЛДЭГ СУДЛААЧ-2018” ШАЛГАРУУЛАХ  
ХУРЛЫН УДИРДАМЖ**

### Үндэслэл

Монгол улсад судалгааны ажлын чиглэл батлагдаагүйгээс доктор, магистрын зэрэг хамгаалахаар хийгдэж байгаа судалгааны ажлууд болон зохиогдож байгаа эрдэм шинжилгээний хурлууд нь салбарын хөгжилд төдийлөн үр өгөөжтэй биш байсаар ирлээ. Энэ явдал тус салбарын хэмжээнд тулгамдаж буй асуудлыг судалгаа, шинжилгээний үндсэн дээр шийдвэрлэх ажил дутагдагтай холбоотой.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар нь Монгол улсын хэмжээнд БТС-ын хөгжлийн бодлого хэрэгжүүлдэг байгууллагын хувьд практикт судалгааг хэрэглээ болгох ажлыг Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний албанаас 2017 онд санаачлан хэрэгжүүлж байна. 2018 оны БТС-ын салбарын шилдэг шалгаруулах ажлыг “БТС-ын салбарт тулгамдаж буй асуудал” нэрийн дор явуулна.

### Зорилго

Салбарын хэмжээнд мэргэжилтнүүдийг судалгаа хийхэд сэдэлжүүлэх, судлаачдыг идэвхжүүлэх, судалгааны цар хүрээг тэлэх зорилготой.

### Зорилт

- Судлаачдын судалгааны чадварыг судлах
- Хийгдэж байгаа судалгааны чиглэл, сэдвүүдийг тодорхойлох
- Гаргаж байгаа бүтээлтэй танилцах

**Хамрах хүрээ:** БТДС, СДС, аймаг, нийслэл, дүүргийн БТСГ, спорт хороо, НЭМҮТ, БМДИ, МҮОХ, спорт холбоо, бусад хамтрагч байгууллага

Шилдэг шалгаруулах үйл ажиллагааг дараах номинациар явуулна.

1. Шилдэг бүтээл
2. Шилдэг илтгэл

### Шилдэг шалгаруулах комисс

- а. “Шилдэг бүтээл” шалгаруулах шүүгчийн багийн бүрэлдэхүүн 3 хүн байна.  
Үүнд:
  1. БСШУСЯ, Боловсролын хүрээлэнгийн секторын эрхлэгч, академич Н.Бэгз
  2. БСШУСЯ, Боловсролын хүрээлэнгийн секторын эрхлэгч, (Ph.D) Б.Баярцэцэг
  3. ЗГХА, БТСГ, САУЭША-ны мэргэжилтэн, (Ph.D), дэд профессор Ш.Долгор

- б. “Шилдэг илтгэл” шалгаруулах шүүгчийн багийн бүрэлдэхүүн 3 хүн байна. Үүнд :
1. АШУИС-ийн Физиологийн тэнхимийн эрхлэгч,(Ph.D) Б.Баасанжаргал
  2. МУЭИС-ийн дэд захирал, (Ph.D), профессор Д.Нармандах
  3. БСШУСЯ-ны ЗГХА, БТСГ-ын САУЭША-ны дарга Ч.Насанбат

**“Шилдэг илтгэл”-д тавигдах шаардлага**

1. Илтгэгч өөрийн CV, товч намтрыг файлаар ирүүлнэ.
2. Судалгааны өгүүлэл нь нэг судлаачийн болон хамтын бүтээл байж болно.
3. Судалгааны өгүүллийн бүтэц болох агуулгыг мөрдсөн 4 хүртэл нүүр байна. Үүнд: судлаачийн нэр, эрдмийн цол,зэрэг, байгууллагын хаяг, цахим хаяг, утасны дугаар, сэдвийн нэр (Монгол, English), абстракт (English) 250 үгэнд багтсан, 5 түлхүүр үг, судалгааны үндэслэл, зорилго, зорилт, судалгааны ашигласан арга, таамаглал, шинэлэг тал, судалгааны үр дүн, ашигласан материал гэсэн дарааллыг баримталсан байна.
4. Өгүүллийг мөр хоорондын зай single, Arial 10 фонтоор бичигдсэн А4 цаасан дээр тал бүрээс 2.5 см зай авсан байна.
5. Судалгаа нь шинэ байна, зарласан хугацаанд ирүүлнэ.
6. Илтгэлийг 2018 оны 10 дугаар сарын 15-25-ны өдрүүдэд файлаар [dolgor@sport.gov.mn](mailto:dolgor@sport.gov.mn) хаягаар ирүүлэх ба Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний албаны 409 тоотод флаш дискээр хүлээн авна.
7. Зөвхөн судалгааны бүтээлийн шаардлага хангасан өгүүллийг хэвлэнэ.

**“Шилдэг илтгэл” шалгаруулах аргачлал:**

“Шилдэг илтгэл” шалгаруулах уралдаанд анхан шатны эрдэм шинжилгээний хурлаас шалгарсан илтгэлийг 2018 оны 10 дугаар сарын 15 өдөр гэхэд ирүүлсэн байна. Шүүгчийн бүрэлдэхүүн 2018 оны 10 дугаар сарын 15-25-ны өдрүүдэд материалыг уншиж танилцана. 11 дүгээр сарын 01 өдөр шалгарсан 9 илтгэгчийг мэдээлж Power Point илтгэл бэлтгүүлнэ. Хуралд материалаа ирүүлсэн бүх хүн оролцоно. Ирүүлсэн материалуудаас шаардлага хангасан 40 илтгэлийг эрдэм шинжилгээний хурлын 2018 оны эмхтгэлд оруулна.

**Биеийн тамир, спортын салбарын “Шилдэг илтгэл-2018” үнэлэх маягт-1**

№	Илтгэлийн нэр	Судлаач нэр	Харгалзах үзүүлэлт (100 оноо)				Илтгэлийн шаардлага хангасан байдал (20 оноо)	Илтгэлийн үнэлгээ	Эзэлсэн байр
			Спортын ШУ-д оруулж байгаа хувь нэмэр (20 оноо)	Судалгааны ажилд ашигласан арга зүй (20 оноо)	Судалгааг хамрах хүрээ (20 оноо)	Судалгааны шинэлэг байдал (20 оноо)			
1									
2									
3									

Илтгэлийн шаардлага хангасан байдал (20 оноо)

УХА0587  
9111891  
1116127249

Илтгэлийн үнэлгээ

Эзэлсэн байр



## “Шилдэг бүтээл”-д тавигдах шаардлага

Шинжлэх ухааны шилдэг бүтээлд дараах бүтээлүүдийг хамруулна. Үүнд:

1. Салбарын эрэлт хэрэгцээнд нийцсэн, онолын өндөр түвшинд хийгдсэн судалгааны ажлын үр дүнг боловсруулан туурвисан ном, зохиол (сурах бичиг хамаарахгүй)
2. Судалгааны үр дүнд бий болсон технологи, биет бүтээгдэхүүн

Нэр дэвшүүлэх бүтээлд дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

- Бүтээл болон түүний зохиогчийн товч танилцуулга
  - Бүтээлийн онол, практикийн ач холбогдлыг хэлэлцэн шинжлэх ухааны шилдэг бүтээлд дэвшүүлэхээр шийдвэрлэсэн эрдэм шинжилгээний байгууллагын эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэр
  - Бүтээлийг үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын үнэлгээ, мэргэжлийн дүгнэлт буюу нэвтрүүлж ашиглах талаар хийсэн гэрээ, хэлцэл
  - Шинэ бүтээлийн патент, ашигтай загварын гэрчилгээ зэрэг зохиогчийг гэрчлэх баримт
3. Шилдэг бүтээл нь БТДС СДС, аймаг, дүүргүүдийн БТСГ зэрэг анхан шатнаас шалгарсан зөвхөн нэг нэг бүтээл хүлээж авна.
    - Бүтээлийг биетээр нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Биеийн тамир, спортын газрын “Шилдэг бүтээл” шалгаруулах комисст гэсэн хаягаар албан тоотоор ирүүлэх ба бичиг хэргээр дамжуулан хүлээж авна.
    - “Шилдэг бүтээл” шалгаруулах уралдаанд анхан шатнаас шалгарсан бүтээлийг 2018 оны 10 дугаар сарын 15 өдөр гэхэд танилцуулгатай нь ирүүлсэн байна. Шүүгчийн бүрэлдэхүүн 2018 оны 10 дугаар сарын 15-25-ны өдрүүдэд бүтээлтэй танилцана. 11 дүгээр сарын 01 өдөр шалгарсан 3 бүтээлийг мэдээлнэ.
    - Шүүгчид шалгуурын дагуу үнэлж хамгийн их оноо авсан бүтээл нь тэргүүн байр эзэлнэ.

## Биеийн тамир, спортын салбарын “Шилдэг бүтээл-2018”-д үнэлэх маягт-2

№	Бүтээлийн нэр	Зохиогч нэр	Харгалзах үзүүлэлт (100 оноо)					Бүтээлийн дизайны загвар (20 оноо)	Шинэлэг байдал (20 оноо)	Бүтээлийн туршигдсан байдал, үр дүн (20 оноо)	Шинэлэг байдал (20 оноо)	Бүтээлийн дизайны загвар (20 оноо)	Нийт үнэлгээ	Эзэлсэн байр
			Спортын Шу.Д оруулж байгаа хувь нэмэр (20 оноо)	Бүтээл олон нийтийн хүртээл болсон байдал (20 оноо)	Партикт туршигдсан байдал, үр дүн (20 оноо)	Шинэлэг байдал (20 оноо)	Бүтээлийн дизайны загвар (20 оноо)							
1														
2														
3														

УХА0587  
9111891  
1116127249